



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 1/07

Амардалай

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага
худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, сумын 2023 оны "Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө"-г үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Дэлгэрцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 40 дугаар тогтоолын дагуу Дэлгэрцогт сумын нутаг дэвсгэрт 1 байршлын 18000 м.кв (1.8 га) газрыг хавсралтад заасан зориулалтын дагуу газар эзэмших эрхийн дуудлага худалдааг цахимаар зохион байгуулсугай.

2. Дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлэх газрын хэмжээ, зориулалт байршил, хугацаа, дуудлага худалдааны анхны үнэ, дуудлага худалдаа явуулах өдрийг хавсралтаар баталсугай.

3. Дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулж, дуудлага худалдааны зар мэдээг www.mle.mn газрын цахим биржид болон мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй зарлан явуулсугай.

4. Дуудлага худалдаа явуулах хугацаа, тавигдах шаардлага нөхцлүүдийг тодорхойлон олон нийтэд зарлан мэдэгдэж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ



Сумын засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/67 дугаар захирамжийн хавсралт



Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газар										
№	Газрын нэр	Газрын байршил нэгж талбар бүрээр	Газрын зориулалт	Хэмжээ м.кв	Анхны үнэ	Дэнчингийн үнэ	Эзэмшүүлэх хугацаа	Дуудлага худалдаа зарлаж эхлэх хугацаа	Дуудлага худалдаа явагдаж эхлэх хугацаа	Дуудлага худалдаа явуулах хэлбэр
0	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Шивээ овоо	X=612453.17 Y=5097858.99 X=612472.40 Y=5097862.65 X=612513.98 Y=5097870.57 X=612548.15 Y=5097877.11 X=612501.86 Y=5098046.92 X=612378.60 Y=5097922.35 X=612428.92 Y=5097854.21 X=612430.10 Y=5097852.68 X=612441.35 Y=5097855.97 X=612453.17 Y=5097858.99	3503: Цахилгаан эрчим хүчний барилга байгууламж	18000	11520000	1152000	15	2023.06.02	2023.07.03	Цахим